

# Үг давтах алдаа

■... *Тэдний хоёр нь газар дээрээ нас барж, нэг нь эмнэлэгт хүрэх замдаа нас барсан гэлээ.*

*(“Зууны мэдээ” 2007.10.31 №260/2708)*

*Энэ өгүүлбэрийн давтсан үгүүдийг хасвал: Тэдний хоёр нь газар дээрээ, нэг нь эмнэлэгт хүргэгдэх замдаа нас барсан гэлээ.*

■... *Тэднийг дотносох болсон талаар ангийнх нь нөхөд ч тэдний талаар шивэр авир ярих болжээ*

*(“Дээдсийн хүрээлэн” 2007.04 сар)*

*Энэ өгүүлбэрийн найруулгын алдааг засаж бичвэл  
Тэднийг дотносох болсон талаар ангийнх нь нөхөд ч ярих болжээ.*

# Гоо зүйн алдаа

- *...Миний ах нэг тийм хиртэй гараар баримгүй цэв цэвэрхэн цагаахан зүйл шиг, хэн дуртай нь дотносоод мөрөн дээр нь гараа тавихааргүй, нэг тийм эгэл, эрч хүчтэй, гялалзсан хурдан алхаатай, сайхан инээдэг яг тийм үгээр илэрхийлэхийн аргагүй “”Эрхэмсэг орчлон” л мэт эр явжээ, одоо бодоход..*

(“Өнөөдөр” 2008.12.03 № 278/3541 “Ах бид хоёр”)

Ахыгаа дурсаж их сайхнаар бичих гэж оролдсон боловч дэндүү болхи, хувь хүний мөн чанарыг илтгэж харуулж чадахааргүй зүйрлэл сонгон авчээ.

- *...Хүмүүсийн сонорыг чангааж буй дууны нэг нь “ээжийн минь чанасан цай” билээ.*

(“Нийгмийн толь” 2007.10.20 № 248/339)

Ард түмэн энэ дууг өөрсдөө сонсохыг хүсдэг. Тиймээс ч өдгөө зохиолын дууны Хитийн тэргүүнд явж байгаа. Гэтэл чангааж гэж бичсэн нь сонсох дургүй байхад сонс гээд чихнээс нь чангааж татаад байгаа мэт болжээ.

Зүй нь: *Хүмүүсийн сонорыг мялайж буй дууны нэг нь “Ээжийн минь чанасан цай” билээ* гэх нь илүү сонсголонтой болох юм.

## Хэл зүйн алдаа

- *Анх 80 гаруй охид оролцсоноос эхний удаад 33 бүсгүйг шалгаруулж, дараагийн шатанд 12 бүсгүй, сүүлийн шатанд таван бүсгүй тунаж үлдсэ*

*(“Хүмүүсийн амьдрал” 2007.03.14 №46/371)*

- *...Монголоос анх удаа Б.Билэгтөгс, Б.Төгсбилэг болон М.Сэлэнгэ, М.Наран зэрэг ихрүүд оролцоод иржээ*

*(“Өнөөдөр” сонин 2006.05.31 №126/2780)*

- *...Монголын парламентын танхимаас анхны хосууд төрөх нь бололтой.*

*(“Дээдсийн хүрээлэн” 2007. 4 сар №10/504)*

Угаасаа ихэр, хос, гэсэн үг нь олны утга илэрхийлдэг

учир олон тооны лагавар шаарллагагвй юм.

# Үг буруу байрлуулах алдаа

- *Анхны Монголчууд Туринд ирэв*

*(“Өнөөдөр сонин” 2006.02.22 №043/2697)*

Сэтгүүлч Туринд анх очсон Монголчууд гэх нь өгүүлбэрийг зөв болгоно. Анхны Монгол хүн гэж ярихад хүрвэл бүр Хүннү гүрэн магадгүй дэлхий дээр бий болсон анхны хүнийг хайх хэрэг ч гарах юм бил үү. Тэгээд ч тэнд очив, тэнд очсон гэж ярихаас биш тэнд ирсэн гэж ярьж бичдэггүй.

- *Бяцхан лусын дагина*

*(“Өнөөдөр” сонин 2007.08.01 №178/3136 D1 нүүр)*

Энэ гарчгийг уншихад **бяцхан лус** гэсэн ойлголт авч байна. Тэгвэл **Лусын бяцхан дагина** гэвэл лус нь том дагина нь бяцхан гэсэн ойлголт авна. Тэгэхээр Бяцхан лус гэж байхгүй нь ойлгомжтой тул **Лусын бяцхан дагина** гэх нь зөв юм.

## Баримтын алдаа

- *...Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр энэ сарын 27-28-ны өдрүүдэд Хэнтий аймгийн ТӨВ Өндөрхаан хотод ажиллалаа.*

(“Өглөөний сонин” 2008.12.01 №231/554)

Сэтгүүлч өнгөрсөн сарын үйл явдлыг энэ сарын гэж бичснээрээ баримтын алдаа гаргасан байна

## Гарчиг, эх бичвэр зөрчилдөх алдаа

- 2006 оны “Зиндаа” сонины нэгэн дугаарт: “Т.Баясгалан: Тааралдсантайгаа сексдэнэ” гэсэн гарчигтай ярилцлага нийтлэгджээ. Ард түмний хайр хүндэтгэлийг хүлээсэн дуучин бүсгүйг “Тааралдсантайгаа сексдэнэ” гээд биччихсэн байхад унших гэсэн хүний тоо нэмэгдэх нь мэдээж. Гэтэл бичвэрт Т.Баясгалангаас сэтгүүлч “Хүн, адгуус амьтан хоёрын сексийн ялгааг тайлбарлаач” гэж асуухад нь Т.Баясгалан “Хүн таалагдсантайгаа, адгуус амьтад тааралдсантайгаа сексддэгээрээ ялгаатай” гэж хариулсан байх юм.